



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2018.07.10 № 1/1495  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ (НИЙСЛЭЛ), ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцож цагдаагийн алба хаасан хугацааг өсгөн нэмэгдүүлэхээр заасан.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус газрын 2017 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 3/3059, 2018 оны 3/326 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн “Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасан ажлын байр (албан тушаал)-ын жагсаалт”-ыг тус тус хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газраас дээрх албан тушаалын жагсаалтын “**эргүүлийн офицер**” хэсэгт группийн дарга, 1950-1980 оны орон нутаг дахь цагдан сэргийлэх хэлтэс, анги, группийн төлөөлөгч, сэргийлэн хамгаалах ахлах байцаагч, байцаагчийн, “**эргүүлийн цагдаа**” хэсэгт шүүхийн цагдаа, салаа, эргүүл, харуул, рот /суман/-ын захирагч, бага дарга, дарга, салааны захирагч, салааны орлогчийн, “**жижүүрийн офицер**” хэсэгт жижүүр хариуцсан ахлах байцаагч, хариуцлагатай жижүүрийн, “**жижүүрийн цагдаа**” хэсэгт нохой хөтлөгч, кобаны цагдаа, нохой дасгалжуулагчийн, “**эргүүлийн цагдаа жолооч**” хэсэгт жолоочийн ажлын байр /албан тушаал/-ын нэршлийг тус тус нэмж оруулах чиглэл ирүүлсэн байна.

Иймд Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу цагдаагийн алба хаагчийн алба хаасан хугацааг тооцоход дээр дурдсан албан тушаалд алба хаасан 1 жилийг цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн 1 жил 3 сараар тооцож цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоож олгох нь зүйтэй.

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 3/4073 тоот албан бичгийг хавсарган хүргүүлэв.

Хувийг Хяналт, шалгалтын газар, Мэдээллийн технологийн төвд.

ДАРГА  Д.ЗОРИГТ

My doc.NDBHSG.SU A-4 /18.07-r sar/

1001589



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ  
ДЭД ДАРГА Г.САРАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж 18. Утас: 7019-1087. Факс: 7019-1087.  
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2018.07.03 № 3/4043

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Чиглэл хүргүүлэх тухай


Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасны дагуу албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд харьяалах ажлын байр /албан тушаал/-ны нэршлийг албан бичгээр хүргүүлэн хамтран ажиллаж байгаа билээ.

Цагдаагийн байгууллагын ажлын байр /албан тушаал/-ны нэршил нь өнгөрсөн хугацаанд өөрчлөгдөж байсан ба тэдгээр албан тушаалуудыг жагсаалтад бүрэн оруулах боломжгүй учир одоогийн албан тушаалын нэршлээр гаргаж өгсөн.

Иймд гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд жагсаалтын “эргүүлийн офицер” хэсэгт группын дарга, 1950-1980 оны орон нутаг дахь цагдан сэргийлэх хэлтэс, анги, группын төлөөлөгч, сэргийлэн хамгаалах ахлах байцаагч, байцаагчийн, “эргүүлийн цагдаа” хэсэгт шүүхийн цагдаа, салаа, эргүүл, харуул рот /суман/-ын захирагч, бага дарга, дарга, салааны захирагч, салааны орлогчийн, “жижүүрийн офицер” хэсэгт жижүүр хариуцсан ахлах байцаагч, хариуцлагатай жижүүрийн, “жижүүрийн цагдаа” хэсэгт нохой хөтлөгч, кобаны цагдаа, нохойн дасгалжуулагчийн, “эргүүлийн цагдаа жолооч” хэсэгт жолоочийн ажлын байр /албан тушаал/-ны нэршлийг тус тус хамааруулан, нэмж тусгуулах саналыг хүргүүлэв.

Хүлээн авч танилцаж, шийдвэрлэж өгнө үү.

ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



З.ДАШДАВАА

0904673